

АКАДЕМИК ШИЛЖИЛТ БУЮУ ЭНТРЕПРЕНЕР ИХ СУРГУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Д.Батцэцэг*, Н.Батдэлгэр**

Хураангуй: Энтрепренер сэтгэлгээ, соёлыг төлөвшүүлэх, энтрепренершип түншлэлийг хөгжүүлэхэд их сургуулийн манлайлал, үүрэг оролцоо их байгаа нь практикт нотлогдож судалгааны их сургуулиас энтрепренер их сургууль болж хөгжих чиг хандлага улам бүр нэмэгдсээр байна. Нийгэм эдийн засгийн хөгжилд нөлөөлж буй талаасаа ч, их сургуулийн сургалт, судалгааны чанар, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж буй талаасаа ч манай улсад академик энтрепренершип болон энтрепренерт чиглэсэн хөгжлийн концепцийг хэрэгжүүлэх, хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Тиймээс академик энтрепренершип болон энтрепренер их сургуулийн тухай үзэл баримтлал, түүхэн хөгжлийн талаар тодруулах, ойлголтыг нэмэгдүүлэх хэрэгцээ байгааг судлаачын зүгээс харж энэхүү судалгааны өгүүлэлийг хэвлүүлэхийг зорьлоо. Судалгаанд 1/энтрепренершиппийн талаар ерөнхий ойлголт, 2/академик энтрепренершип болон академик энтрепренерийн тухай, 3/ энтрепренер их сургуулийн онцлог шинж чанар, үзэл баримтлал, ач холбогдлыг талаарх судалгааны ажлуудыг харьцуулан судлаж, нэгтгэн харуулсан тул энэ чиглэлээр сонирхон судлаж буй бүх түвшний оюутнууд, судлаачдад тодорхой мэдлэг, мэдээллийг олгох ач холбогдолтой болно.

Түлхүүр үгс: Академик энтрепренершип, академик энтрепренер, энтрепренер их сургууль

Academic transition and the concept of an entrepreneurial university

Abstract: It has proven that universities' roles increase in cultivating an entrepreneurial mindset, culture and developing entrepreneurial partnerships. Therefore universities across the world in moving from research institutions to a more entrepreneurial mode. Our universities need to implement academic entrepreneurship and entrepreneurial-oriented development concept considering their effect on social and economic development in a country and research quality and competitiveness of the university.

The paper aimed to study the concept and historical development of academic entrepreneurship and the entrepreneurial university for future research advancement. The study compared and summarized 1/the understanding of entrepreneurship 2/ the concept of academic entrepreneurship and academic entrepreneur 3/ the characteristics, concepts, and importance of entrepreneurial universities. The contribution of this study is to provide profound knowledge and information about academic transition for postgraduate students and researchers.

Key words: Academic entrepreneurship, academic entrepreneur, entrepreneurial university

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): dalkhbattsetseg@gmail.com

** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): batdelger.n@num.edu.mn

Удиртгал

19-р зууны үед Кардинал Жон Ньюман хамгийн төгс их сургуулийг “өөрийнхөө төлөө мэдлэгийг ашигладаг сургууль” гэж тодорхойлсон байдаг. Түүнийхээр их сургууль нь шинжлэх ухааны туршилт, судалгаа, нээлт хийх хамгийн хүчтэй институци бөгөөд үүнийгээ эргээд өөрөө ашиглах чадавхитай гэдгийг илэрхийлсэн нь 21-р зуунд биелэлээ олж байна. Мэдлэгийг ашиглах зохиостой арга зам нь академик энтрепренершипийг хөгжүүлэх, их сургууль энтрепренер чиг баримжаатай хөгжих явдал. Энэ утгаараа дэлхий нийтээр бүс нутгийн болон үндэсний инновацийн тогтолцоонд мэдлэгийг чухалчилж оюуны бүтээлийг патентжуулах, арилжаалах, зах зээлд хүргэх, старт-апп, спинн-оффудын төрүүлэн гаргах энтрепренер их сургуулийн хөгжлийн хандлагыг илүүд үзэх болжээ. Их сургууль уламжлалт байдлаар сургалт, судалгааны чиг үүргээ биелүүлэх нь түүний хөгжлийг хязгаарлаж, удаашруулсаар байх болно, тиймээс гадаад орчны хурдацтай өөрчлөлтөд хариулт өгөхийн тулд их сургууль энтрепренершипийг хөгжүүлэх, академик шилжилт хийх чухал үетэй нүүр тулж байна. Энэ тухай олон эрдэмтэн, судлаачид тайлбарлаж, нотолсоор ирсэн. Тухайлбал Хенри Этцковиц эрдэмтэдийн судалгааны ажил болон түүний хэрэглээний хооронд асар их зөрүү байна. Үүнийг ойртуулахын тулд судалгааны үр дүнгээ хэвлэн нийтлүүлж, шинжлэх ухаанд хувь нэмэр оруулах уламжлалт хандлага, судалгааны ажлын үр дүн нь арилжааны болон оюуны чадавхиар илэрхийлэгддэг энтрепренер хандлага гэсэн хоёр хөгжлийн чиг хандлага байгааг олж харах, үүнийг хослуулан хөгжүүлэх шаардлага их сургуулиудын өмнө тулгарч эхнийхээс сүүлийнх руу шилжих шилжилт өрнөж байна (Etzkowitz, 1998) гэдгийг онцолсон байдаг. Тиймээс академик шилжилт хийх, их сургууль энтрепренер байхын ач холбогдолыг тодруулахын тулд энэхүү судалгааны ажлыг хийхээр зорьсон. Үндсэн агуулга руу орохын өмнө суурь ойлголт болох энтрепренершип болон энтрепренерийн тухай үзэл баримтлалыг танилцуулсан нь логик ач холбогдолтой гэж үзлээ.

Энтрепренершипийн тухайд

Эрдэмтэд судалгааны үр дүн дээрээ тулгуурлан “энтрепренершип”-ийг өөр өөрийнхөөрөө тодорхойлсон байдаг боловч тэдгээрээс нэг нь ч давамгайлж чадаагүй. Энтрепренершип гэдэг нь чухам юу болохыг оновчтой тодорхойлсноор түүнийг тайлбарлах, судлах, хөгжүүлэх аливаа үйл ажиллагаа зөв зохистой болно. Ихэнх эрдэмтэдийн дэвшүүлсэн тодорхойлолт эдийн засагч Шумпетер /1934/-ийн “энтрепренер бол хэвшмэл байдлыг эвдэж шинэ хослолыг /new combination/ хэрэгжүүлж байдаг хувь хүн”, энтрепренершип бол бүтээлч сүйтгэл /creative distraction/ гэсэн ойлголт дээр үндэслэгддэг. Түүнийхээр

энтрепренершип бол эдийн засгийн системд өрсөлдөх чадвартай үлдэхийн тулд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, процесс эсвэл шинэ бизнесийн загварыг зах зээлд танилцуулах явдал юм.

Салбарын судлаачид энтрепренершипыг шинэ байгууллага бий болгох үйл явц (Murrey B. Low, 1988), (Gartner, 1988), өндөр үр ашиг бүхий бизнесийг эхлүүлэх /санаачлах/, дэмжих, хөгжүүлэх зорилготой үйл ажиллагаа (Cole, 1949), бэлэн байгаа нөөцүүдээс илүү шинэ боломжуудыг олж, үнэлж, ашиглах үйл явц (Stevenson, 1990), (Simon C. Parker, 2010), мэдлэгийг үнэ цэнэ бүхий шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргах үйл ажиллагаа (S.Venkataraman), өсөн нэмэгдэх баялагийг бүтээх динамик процесс (Robert Ronstadt, 1988), өмнө нь байгаагүй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, зохион байгуулалтын арга хэлбэр болон шинэ процессыг танилцуулах үйл ажиллагаануудыг багтаасан ойлголт (Shane, 2003), цаг хугацаа, хүчин чармайлтаа зориулан тодорхой эрсдлийг үүрч, үнэ цэнийг бүтээж үр дүнд нь шагнал хүртдэг үйл явц (Robert D. Hisrich, 2008) гэх мэтээр тайлбарласан байдаг. Дээрх тодорхойлолтууд нь энтрепренершипыг “шинэ зүйлсийг бүтээх үйл явц /process/ гэж тайлбарласан бол зарим эрдэмтэд энтрепренершип бол үйл явц биш механизм, арга зам / mechanism, method/ юм гэдгийг онцолсон байдаг. Тухайлбал нар (Neck, 2018) энтрепренершип бол шинэ боломжийг олох, бий болгох чадварыг, бүтээх хүсэл эрмэлзэлтэй нэгтгэн ойлгох, сэтгэх, үйлдэх арга зам, (Tidd, 2015) энтрепренершип бол хүсэл эрмэлзэл бүхий хувь хүн, баг болон төвлөрсөн нэйтворкийн хүчин чармайлтаар инновацийн үйл явцыг жолоодох, хөдөлгөгч хүч, (M.Kirzner, 1977), (Erik Stam, 2008) эдийн засаг дахь үр өгөөж багатай орон зайг илрүүлж түүнийг өөрчлөх механизм, (Dollinger, 2008) эрсдэлтэй болон тодорхойгүй нөхцөлд бизнесийн ашиг олох хувь хүн, байгууллагын хүчин чармайлт, ур чадвар юм гэж тус бүр тодорхойлсон байна. Эдгээр эрдэмтдийнхээр энтрепренершип бол эрсдэлтэй, тодорхойгүй нөхцөлд өөрчлөлт, инноваци хийх арга зам бөгөөд хувь хүн болон багийн өвөрмөц ур чадвар, хүчин чармайлтыг шаарддаг байх юм. Тэгэхээр энтрепренершип нь боломж, үнэ цэнэ, шинэ бүтээгдэхүүн, шинэ бизнес, эрсдэл, нийгэм эдийн засгийн үр ашиг, хамтын хүчин чармайлт, ур чадвар зэргийг багтаасан өргөн утга агуулга бүхий ойлголт юм. *Зураг 1-т энтрепренершипыг агуулгад хамаарах ойлголтуудыг нэгтгэн харуулав.*

Дээрх тодорхойлолтуудыг нэгтгэн энтрепренершип бол шинэ мэдлэгийг нийгэм, эдийн засгийн өндөр үр ашиг бүхий бизнес болгон хөгжүүлэхэд оролцож буй талуудын хамтын ажиллагаа, хүчин чармайлт, ур чадваруудын нэгдэл, тэдгээрийг оновчтой удирдах арга зам гэж дүгнэж болох юм. Эндээс оролцогч талуудын үүрэг оролцоо, харилцан хамаарал, гаргаж буй

хүчин чармайлт, ур чадваруудыг тодорхойлох, үнэлэх, оновчтой удирдлагын арга хэрэгслүүд, тэдгээрийн практик хэрэглээ, үр дүн, ач холбогдолыг судлах, тайлбарлах боломжтой болох юм гэж судлаачдын зүгээс үзэж байна.

Энтрепренер гэж хэн бэ?

Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, үнэ цэнэ нь энтрепренеруудын ур чадвар, нөөцүүдийг ашиглалт, хүчин чармайлтаар бүтээгдсэн байдаг (Robert Ronstadt, 1988). Тэгвэл энтрепренер гэж хэн бэ? тэдэнд бусдаас ялгарах өвөрмөц шинж чанар бий юу? тэднийг юу энтрепренер болоход нөлөөлдөг вэ? гэдэгт эрдэмтэд одоог хүртэл хариулт хайсаар байна. (S. Venkataraman, Scott Shane, D. Sarasvathy) нарын эрдэмтэд “боломж”-ийг хэн, хэрхэн, ямар тохиолдолд ашиглаж байна, тэдэнд боломжийг таньж, ашиглахад юу нөлөөлж байгааг судласнаар энтрепренер болон энтрепренершипийн тухай ойлгох болно гэсэн хариултыг өгсөн байдаг.

“Энтрепренер хүн”-ийг шинийг санаачлагч /innovator/, эрсдлийг хүлээн авагч /risk taker/, өөрчлөлтийг хэрэгжүүлэгч /change agent/, шинэ бизнес эрхлэгч /new enterprise/, эдийн засгийн нөөцүүдийг зохицуулагч /organizer and coordinator of economic resources/ гэж янз бүрээр тайлбарласан байдаг. Энтрепренер бол ашиг, орлого бүхий боломжийг олж харан одоо байгаа нөөц нь хангалтгүй ч үйл ажиллагаагаа эхлүүлдэг (Kirzner, 1985), зах зээлийн нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэн эрэлт, хэрэгцээтэй байгаа бараа, үйлчилгээг зах зээлд хүргэх шаардлагатай бүх нөөцийг эзэмшсэн хүн Leibenstein (1968) юм. Энтрепренерүүд бол “ашиг болон эрсдэл өндөртэй шинэ, өвөрмөц технологи бүхий бизнесийг эхлүүлж буй хувь хүн” бөгөөд тэд өөрийн бизнесийн ашиг, нэр хүнд, эрх мэдэлээ өсгөхийн тулд бусдаас илүү ухаалаг, бүтээлч, эрсдэл үүрэх чадвар, өөрчлөлт хийх хүсэл эрмэлзэлтэй (Baumol, 1990) байдаг. Бизнес эхлүүлж буй хүн бүрт шинэ санаа бий гэхдээ санаагаа боломж болгон ашиглах чадвар энтрепренеруудад л байдаг, харин боломжийг бизнес болгох арга хэрэгсэл нь инноваци (Joy, 2015) болдог мөн тэд бие даасан байдал, ур чадвараа өргөнөөр ашиглах, өөрийн санаа, зорилгоо хэрэгжүүлэх боломж, эрх чөлөөг илүүд үздэг (Sen 1999) гэдгийг судлаачид онцолдог. Тэгэхээр “энтрепренер” бол боломжийг ашиг өндөртэй бизнес болгон хувиргаж чаддаг, үүний тулд тодорхой цаг хугацаа, хүчин чармайлт зориулдаг, шинийг эрэлхийлэгч, эрсдлийг даван туулах чадвартай, бүтээл сэтгэлгээтэй, хийх хүсэл эрмэлзэлээ бодит болгож чаддаг хувь хүн гэж тодорхойлж болох юм.

Зураг 1. Энтрепренершипийн хамрах хүрээ

Энтрепренершип-Entrepreneurship					
<p><u>Боломж- opportunity</u></p> <p>Зан төлөв Ур чадвар Хүсэл эрмэлзэл Нөөцүүд</p>	<p><u>Үнэ цэнэ -Value</u></p> <p>Мэдлэг Туршлага Санаачлага Бүтээлч сэтгэлгээ</p>	<p><u>Шинэ хослол- New combination</u></p> <p>Инноваци Шинэ бүтээг- дэхүүн, үйлчилгээ, технологи</p>	<p><u>Шинэ байгууллага- New business/ organization</u></p> <p>Старт-апп Спин-офф</p>	<p><u>Эрсдэл - Risk</u></p> <p>Тодорхойгүй нөхцөл байдал Эрсдэл даван туулах чадвар</p>	<p><u>Үр ашиг</u></p> <p>Ашиг Сэтгэл ханамж Энтрепренер соёл Нийгэм, эдийн засгийн үр өгөөж</p>
Энтрепренер – Entrepreneur					

Судлаачын дүгнэлт

Академик энтрепренершип буюу академик шилжилт

АНУ-д 1980 онд Бэй Доулийн хууль гарснаас хойш шинжлэх ухааны мэдлэгийг арилжаалах үйл явц буюу их сургуулиуд дээрх технологи дамжуулах оффисын үйл ажиллагаа маш хурдацтай хөгжсөн (Donald S. Siegel, 2015). АНУ дахь их сургуулиудын оюуны өмчийн патент, лиценз ашиглалт, спин-офф, старт-апп компаниудын өсөлт дэлхийн бусад орнуудын анхаарлыг татаж Европи, Ази, Австрали, Канад, Израйлд энэхүү туршлагыг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ үеэс их сургууль дээр бий болж буй мэдлэг, мэдлэгийн хуримтлалыг эдийн засгийн эргэлтэд оруулах, арилжаалах үзэгдлийг “академик энтрепренершип” гэж нэрлэх болсон. Академик энтрепренершип нь тодорхой, өвөрмөц онцлог бүхий энтрепренершипийн нэг төрөл болон хөгжиж байгаа бөгөөд уламжлалт, арилжааны бус академик орчноос энтрепренер эрдэмтэд бий болох, их сургуулийн багш, оюутнууд оюуны өмчийн патент эзэмших, технологийн старт-апп, спин-оффүүдыг байгуулах, их сургууль-аж үйлдвэрийн хамтын ажиллагааг ойртуулах зорилготой үйл ажиллагаануудыг багтаасан ойлголт. Академик энтрепренершип гэдэг бол шинэ бүтээгдэхүүн, технологи нь их сургуулийн лабораторит бий болсон, академик тэнхим, нэгжид харъяалагддаг эрдэмтэн, судлаач шинэ компани үүсгэн байгуулах явдал (Roberts, 1991), академик орчинд судалгаанд суурилсан бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сурталчилах замаар хувь хүн болон байгууллагын ашиг, нэр хүнд, нийгэм дэх нөлөөллийн нэмэгдүүлэх оролдлого (Louis, 1989), академик мэдлэгийг арилжаалах, ашиг тустай технологи дамжуулах аливаа хэлбэрийг багтаасан ойлголт (Jain, 2009) гэж олон янзаар тайлбарласан байдаг. Энтрепренершипийн академик ертөнцтэй холбосноор эрдэм шинжилгээний ажилтнууд өөрсдийн судалгааны ажлаа эдийн засгийн хэрэгцээ, арилжааны үйл ажиллагаатай шууд холбох шинэ үзэгдэл бий

болсноор (Martin, 2012) “академик энтрепренер” гэх шинэ нэр томъёо гарч ирсэн. Тэгвэл академик энтрепренер гэдэгт судалгааны үр дүнгээ бодитоор хэрэгжүүлэх зорилготой, мэдлэгийн үнэ цэнийг өсгөх, арилжаалах үйл явцад идэвхитэй оролцдог факультетийн гишүүд /их сургуулийн багш/, судлаачдыг багтаан ойлгодог бөгөөд тэд оюуны өмчөө патентжуулах, үйлдвэрлэлд ашиглах, шинэ технологийн компани үүсгэн байгуулах зэргээр байгууллагын болон нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулдаг байна. Судлаачид их сургуулийн профессор багш нарыг арилжааны үйл ажиллагаанд татан оролцуулах нь мэдлэг дамжуулах зарим дутагдлыг арилгаж, тэднийг эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүдэд оролцоход түлхэц болдог гэж үздэг (Gibbons et al., 1994; Zucker and Darby, 1995; Etzkowitz, 2004). Гэвч зарим судлаачид их сургуулийн профессор багш нарын академик зорилго, дүрэм журмыг мөрдөхийн хажуугаар арилжааны үйл ажиллагааг удирдах чадварт эргэлздэг гэдгээ илэрхийлдэг. (Dasgupta and David, 1994; Stern, 1995; Heller and Eisenberg, 1998; Nelson, 2004).

Академик энтрепренершипийг хөгжүүлсэн, энтрепренер чиг баримжаатай /энтрепренер их сургууль/ хөгжлийн стратегийг хэрэгжүүлсэн сургуулиудад дараах үр дүн гарсан байдаг. Үүнд:

1. Их сургууль дээрх технологийн дамжуулах оффис, хамтарсан судалгааны төв, инкубатор, хурдасгуур, шинжлэх ухаан технологийн паркийн өсөлт, хөгжил
2. Энтрепренершип курсууд болон хөтөлбөрүүдийн өөрчлөлт, хөгжил
3. Энтрепренершип клуб, төвүүдийн өсөлт
4. Их сургуулийн эрдэмтдийн эзэмшиж буй патент, шинэ бүтээлийн өсөлт
5. Их сургуулиас төрөн гарч буй технологийн старт-апш, спин-оффүүдыг өсөлт
6. Энтрепренершипийн экосистемийн бүрдүүлэхэд зориулсан төгсөгчид, ажил олгогчдын дэмжлэг, санхүүжилтийн өсөлт г.м

Гэвч их сургуулиуд академик шилжилт хийхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлүүд байсаар байна. Үүнд:

- Академик орчин нь бизнес болон арилжааны үйл ажиллагаанаас ангид сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх нөхцөл бүрдсэн байх ёстой гэсэн уламжлалт хандлага;
- Оюуны өмч, лицензийн зохицуулалт хийх нь нарийн төвөгтэй, ашиг сонирхолын зөрчил, ёсзүйн асуудлууд их гарах учир энэ нь их

сургуулиас ангид байх ёстой гэсэн үзэл;

- Академик орчин нь угаасаа шинэ мэдлэгийг бий болгох, түгээх газар боловч тухайн технологи, бүтээгдэхүүнийг ашиглаж болох худалдан авагчдаас өөрийгөө тусгаарлах хандлага (“зааны ясан цамхаг” синдром);
- Ашгийн бус академик орчинд ашгийн төлөө ажиллах, бизнес эрхлэх оролдлого хийх нь соёлын болон хууль эрх зүйн хувьд харшлах зүйл гэсэн үзэл

Академик хувьсгал ба “Энтрепренер их сургууль”-ийн үүсэл хөгжил

Академик нэгдүгээр хувьсгалын үед (19-р зууны сүүл үе) мэдлэг, соёлыг хуримтлуулах, хамгаалах, сурган өвлүүлэх зорилго бүхий их сургуулиудын байр суурь өөрчлөгдөн шинжлэх ухаанч судалгааны ололт, амжилтыг практикт нэвтрүүлэх, сургалт судалгааг хослуулан ажиллах зорилтуудыг өмнөө тавих болсон. Эдгээр зорилтууд нь академик хоёрдугаар хувьсгалын үед сургалт, судалгааг хослуулахын дээр их сургууль өөрөө энтрепренер байх, энтрепренер үйл ажиллагаагаараа эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах гэсэн гуравдагч зорилтуудаар баяжигдсан. Энэ хувьсгалын үндсэн үзэл санаа 1862 онд Массачусетсийн Технологийн Их Сургууль дээр “ланд грант” загвараар танилцуулагдаж байсан бол 20-р зууны эхэн үед “энтрепренер их сургууль” загвараар Станфордын их сургуульд амжилттай хэрэгжсэн түүхтэй байдаг. Тодруулбал академик нэгдүгээр хувьсал нь шинжлэх ухааныг хөгжүүлэн дэлгэрүүлсэн бол хоёрдугаар хувьсал нь түүнийг амьдралд хэрэгжүүлсэн юм (Etzkowitz, 2013).

Эрдэмтэд энтрепренер их сургуулийн эрхэм зорилго нь сургалт, судалгаа, энтрепренер үйл ажиллагааг хослуулан ажиллахад чиглэгддэг (Etzkowitz, 2003); энтрепренер их сургуулийн зорилтууд нь нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулахад оршдог (Schulte, 2004) гэж онцлон тэмдэглэсэн байдаг. Эрдэмтдийн тодорхойлсноор “Энтрепренер их сургууль” нь шинжлэх ухааны ололт, мэдлэгт суурилсан шинэ бүтээгдэхүүнийг бий болгох, түүнийгээ эзэмших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, зах зээлд хүргэх, технологийн компани, спин-оффудыг төрүүлэн гаргах замаар бүс нутгийн болон улс орны эдийн засагт хувь нэмэр оруулах үүрэг хүлээсэн бие даасан институци юм. Өөрөөр хэлбэл их сургууль сургалт, судалгааны үндсэн чиг үүрэг дээрээ бизнес эрхлэх үүргийг давхар хүлээж буй хэрэг юм.

Энтрепренер их сургуулийн тухай үзэл баримтлал

Дээр дурьдсанчлан их сургуулийн хөгжлийн чиг хандлага мэдлэгийг түгээн

хөгжүүлдэг сургалт, судалгааны их сургуулиас мэдлэг бүтээж ашиглалтад оруулдаг “энтрепренер их сургууль” руу чиглэх болжээ. Учир нь их сургуульд бэлэн байгаа нөөц, чадавхи нь шинэ технологийг бий болгох хамгийн тохиромжтой газар бөгөөд энд бий болсон мэдлэгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах нь улс орны хөгжлийн хурдасгуур болж байгааг MIT, Harvard, Oxford зэрэг их сургуулиудын жишгээр харж, дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна. АНУ-аас эхтэй их сургуульд түшиглэсэн энтрепренершипийн хөгжлийн энэхүү хандлага Европ болон Азийн орнуудад түгэн дэлгэрч, ач холбогдол нь улам бүр нэмэгдсээр байна. Иймээс улс орнууд бүс нутаг, улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийг хурдасгах, үүнд их сургуулиудын оролцоо, хувь нэмрийг өсгөхийн тулд академик энтрепренершипийг хөгжүүлэхэд ихээхэн анхаарах болсон.

Анх энтрепренершипийн эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийн тухай эдийн засгийн онолын эрдэмтэд танилцуулж байсан ба J.Schumpeter (1934) инноваци гэдэг бол нөөцүүдийн шинэ хослол бөгөөд инновацийн үйл явцтай мэдлэгийг нийцүүлэх нь энтрепренершипийн үндсэн үүрэг юм, (Ricke, 1988) ил болон далд мэдлэгийг практикт ашиглах нь эдийн засгийн өсөлтийн суурь болно гэдгийг тус тус тайлбарласан төдийгүй мэдлэгийг үйлдвэрлэгч их сургуулиудын энтрепренершипт оруулах хувь нэмэр чухал болохыг онцолсон байдаг. Их сургууль энтрепренер чиг баримжаатай хөгжих хэрэгцээ, шаардлага, нөлөөлөх хүчин зүйлс, бий болж буй үр өгөөжийг дэлхийн олон орны эрдэмтэд өөрсдийн судалгааны үндсэн дээр тайлбарласан байдаг ба их сургууль энтрепренершипийг хөгжүүлэхийн тулд стратегийн өөрчлөлт хийх, энтрепренер боловсрол олгох, соёлыг төлөвшүүлэх, старт-ап, спин-оффудыг дэмжих дэд бүтцийг бий болгохын ач холбогдлыг энэхүү туршлагыг хэрэгжүүлж байгаа сургуулиуд дээр харуулсан нь их.

Ж.Шумпетерийн (Joseph Schumpeter, 1934) үзэл баримтлал: Хөгжил бол зөвхөн нөөцийн бэлэн байдал болон түүний өсөлтөөр тодорхойлогдохгүй харин системийн дотоод динамик, гадаад нөхцөл байдлын харилцан хамаарлаас шалтгаалдаг. Нөөцүүдийн шинэ хослолыг бий болгохыг инноваци гэх ба их сургуулиудад инновацийг хөгжүүлэх асар их боломжууд байдаг хэдий ч тэд өгөгдсөн боломжийг маш бага ашигладаг. Үүнийг X-inefficiency гэнэ. Тэгэхдээ их сургуулиуд ямар ч үед, хэдий ч өгөгдсөн нөөцийн хүрээнд гарцынхаа үнэ цэнийг өсгөх хангалттай чадавхитай. Нөгөө талаас их сургууль бүр шинжлэх ухааны сургалт, судалгаа, хөгжлийн түүхэн замналтай, тэнд бэлэн байгаа нөөцүүд (орц)-ийн хүрээнд шинэ хослолыг бий болгож илүү өндөр үр дүнд (гарц) хүрэх дундрашгүй боломжууд бий. Тиймээс их сургуулиуд одоо байгаа нөөц, чадавхи, боломжоо ашиглан X -үр ашиггүй байдлыг бууруулах, орцын

шинэ хослолыг бий болгох, инновацийг эрчимжүүлэх, энтрепренершиппийг хөгжүүлэх, энтрепренер байгууллага болон хөгжих зайлшгүй шаардлагатай. Шумпетерынхаар том фирмүүд бус шинэ бизнесүүд, старт-аппууд технологийн инновацийг хийдэг, тэд шинэ баялагийг бүтээж, эдийн засгийн асар их үр ашгийг авчирдаг. Учир иймээс их сургуульд бий болж буй мэдлэгийн чанарыг сайжруулах, хэрэглээнд оруулахын тулд энтрепренершиппийг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэдг ийг онцлон тэмдэглэсэн байдаг.

Ж.Рочн (Jochen Roepke, 1998)-ийн үзэл баримтлал: Шинэ санаа мэдлэгээр дамжин бүтээгдэхүүн, үйлчилгээ болон хувирч, зах зээл хэрэглэгчдийн гарт хүрдэг. Санаа мэдлэгээр дамжин бодит болж зах зээлд хүрэх нь олон хүчин зүйлийн нөлөө, оролцогч талуудын хамтын ажиллагаа, хүчин чармайлтын үр дүн байдаг. Үүнтэй адил шинжлэх ухааны мэдлэгийг эдийн засгийн эргэлтэнд оруулахад их сургууль гол үүргийг гүйцэтгэх хэрэгтэй. Мэдлэгийг эдийн засагт ашиглах нь далд мэдлэгийг ил болгох, нөөцийн шинэ комбинацийг бий болгох, оюуны бүтээлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг маш олон асуудлуудыг их сургуульд авчирдаг. Үүний гол шийдэл нь уламжлалт сургалт, судалгааны байгууллагаас энтрепренер сургууль болон өөрчлөгдөх юм. Энтрепренер чиг баримжаатай хөгжил гэдэг нь дараах үндсэн 3-н утгатай. Үүнд:

1. Их сургууль өөрөө энтрепренер байгууллага болох;
2. Их сургуулийн багш, оюутнууд, ажилчид энтрепренер болох;
3. Их сургуулийн орчинтойгоо харилцах харилцаа, их сургууль, бүс нутгийн хоорондын бүтцийн уялдаа нь энтрепренер замналыг баримтлах

Эдгээр гурав нөхцөл гурвуулаа хангагдаж байж их сургууль энтрепренер байж чаддаг бөгөөд уламжлалт хэв маягаа хадгалсаар байвал хэзээ ч энтрепренер болж чадахгүй. Тэрээр их сургууль шинжлэх ухаанд суурилсан мэдлэгийг бүтээж, түгээхийн тулд байгууллагын дотоод өөрчлөлт, стратегийн шинэчлэл, зохион байгуулалтыг сайн хийх хэрэгтэй бөгөөд оюутнууддаа 1/ компаниудад мэдлэгээ шилжүүлэх, 2/ шинэ компани үүсгэн байгуулж буй хувь хүнд мэдлэгээ шилжүүлэх, 3/ өөрөө шинэ бизнес эрхлэх мэдлэг, чадварыг олгох зорилтуудыг биелүүлэх хэрэгтэйг онцолсон байдаг.

Х.Этцковици (Henry Etzkowitz, 2000)-ийн үзэл баримтлал: Тэр их сургуулиуд төрөлхийн инкубатор юм гэж тодорхойлсон нь угаас их сургууль нь мэдлэгийн эх уурхай бөгөөд мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах нөөц бололцоо хангалттай бий гэдгийг илэрхийлсэн зүйл юм. Х.Этцковицийн их сургууль-аж үйлдвэр-засгийн газрын хамтын ажиллагааны гурвалсан ороомог /triple helix/ загвар нь эдгээр гурван өөр институциуд хэдийгээр бие даасан,

өөр өөрийн чиг үүрэгтэй боловч энтрепренершипийг хөгжүүлэхийн тулд хоорондоо харилцан хамааралтай бие биенийхээ зарим чиг үүргийг хүлээсэн холимог бүтэцтэй /hybrid organization/ байгууллага болж байна. Энэ гурван институцийн нэг болох их сургууль мэдлэгийг хэрэглээнд оруулахад илүү санаачлагатай ажиллаж аж үйлдвэр, бизнесийн байгууллагуудтай хамтарсан лаборатори, судалгааны ажлыг хөгжүүлэх, технологийн старт-апп, спин-оффудыг төрүүлэн гаргах, оюуны өмчийг арилжаалах дэд бүтцийг хөгжүүлэх, их сургуулийн дотоод стратеги, бүтэц, соёлын шинэчлэлийг хийх зайлшгүй шаардлагатай байгааг өөрийн бүтээлүүдээрээ илэрхийлсэн байдаг. Түүнийхээр энтрепренер их сургууль бол судалгааны сургуулийн урвуу шугаман загварыг сонгодог шугаман загвартай нэгтгэн хөгжүүлсэн хэлбэр гэж тайлбарласан бөгөөд их сургуулиудын өмнө гуравдагч зорилго /third mission/-ыг биелүүлэх сорилт тулгарч байгааг анхааруулсан байдаг.

Энтрепренер их сургуулийн тодорхойлолт

Энтрепренер их сургуулийн үзэл баримтлал нь сургалт, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлж, инновацийн хөгжилд мэдлэгийн үүрэг, ролийг нэмэгдүүлэхэд оршдог. Учир нь их сургууль бол мэдлэгийг бий болгож, түгээдэг төдийгүй шинэ технологийг зардал багатайгаар шилжүүлэх институци мөнхийн хувьд инноваци, энтрепренершипийн хөгжилд гол үүргийг гүйцэтгэх шаардлагатай гэдгийг судлаачид танилцуулсаар ирсэн. Энэ утгаараа энтрепренер их сургуулийн онцлог, өвөрмөц шинж чанарыг судлах ажлууд үргэлжилэн энтрепренер их сургуулийн талаар маш олон тодорхойлолтуудыг дэвшүүлсэн байдаг. Эдгээр тодорхойлолтуудаас давхцаж байгаа шинж чанарууд нь:

- Их сургууль засаглалын хувьд бие даасан байх
- Шинэ бизнесийг бий болгох
- Байгууллагын бүхий л түвшинд энтрепренер үйл ажиллагааг хөгжүүлэх, гишүүдэд энтрепренер боловсрол олгох;
- Нийгмийн өөрчлөлтөд хурдтай хариу үйлдэл үзүүлэх, уян хатан байх бүтэц, стратегийг хэрэгжүүлэх;
- Орлогын олон төрлийн эх үүсвэрүүдтэй байх;
- Засгийн газар болоод аж үйлдвэр, бизнесийн байгууллагуудтай харилцаа холбоо сайн байх;
- Улс орон, бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилго г.м

(Clark, 1998), Kirby (2002a), (Etzkowitz, 2003) нарын эрдэмтдийнхээр

энтрепренер их сургууль бол боломжийг бий болгодог, таньж мэддэг, бүтээдэг, эрсдлийг үүрдэг, нийгмийн өөрчлөлт, сорилтод хариу өгдөг, аливаа шилжилт, өөрчлөлтийг хийх чадвартай бие даасан байгууллага бөгөөд энтрепренер байх ((Rourke, 1988), (M. Jacob, 2003) чиг үүргийг хэрэгжүүлснээр их сургуулиудын сургалт, судалгааны чанар дээшилж, санхүүгийн хувьд бие даасан байх нөхцөл бүрддэг. Институцийн онолоор их сургуулиуд гадаад, дотоод орчны хүчин зүйлсийн нөлөөллийг удирдаж ажиллах нь зүйтэй бөгөөд юуны түрүүнд институцийн дотоод өөрчлөлт, шилжилтийг хийх шаардлагатай болдог. Институцийн дотоод өөрчлөлтийн хүрээнд их сургууль нь сургалт, судалгаа, энтрепренер чиг үүргүүдийг холбож нэгтгэсэн алсын хараа, стратегийг тодорхойлох, зохион байгуулалтын уян хатан бүтцийг бий болгох, шийдвэр гаргалт дахь хамт олны оролцоог нэмэгдүүлэх, мэдээлийн доороос дээш урсгалыг ашиглах, менежментийн засаглалын хувьд бие даасан (Clark, 1998) байхыг шаарддаг. Мөн соёлын хувьд байгууллагын нийт гишүүдийг энтрепренер байхад дэмжих, урамшуулалын оновчтой системийг нэвтрүүлэх, спин-офф, гарааны компаниудыг дэмжих механизмууд бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тавигддаг. Энтрепренер их сургуулийн өөр нэг онцлог бол энтрепренер сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх байдаг. АНУ болон Европын орнуудад 1980 оны сүүлээс их дээд сургуулиудад, тэр дундаа бизнесийн сургуулиудад энтрепренершип сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Энтрепренершип сургалтын хөтөлбөрийн зорилго, сэдэв, арга барилууд нь оюутны бүтээлч болон шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлж, энтрепренер зан төлөв, хандлага, ур чадварыг суулгаж өгдөг байна. Ингэснээр нийгэмд ажил хайгч мэргэжилтэн бус, ажлын байраа өөрөө бий болгодог, амжилттай ажиллах, потенциал бүхий энтрепренерүүдийг төрүүлэн гаргадаг ач холбогдолтой.

Хүснэгт 1. Энтрепренер их сургуулийн тухай тодорхойлолтууд

Эрдэмтдийн нэрс	Энтрепренер их сургууль гэдэг нь...
(H.Etzkowitz, June 1983)	...патент эзэмших, гэрээт судалгаа хийх, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй түншлэх зэргээр хөрөнгийн шинэ эх үүсвэрийг бий болгож буй их сургуулиуд...
(Davies, 1987)	... гадаад ертөнцийн хэрэгцээнд тохируулах хувьсан өөрчлөгдөж, шинэчлэгдэж чаддаг их сургууль
Chrisman et al 1995	... профессор, ажилчид, оюутнууд нь шинэ бизнесийг үүсгэн байгуулж чаддаг их сургууль...
(Clark, 1998)	Үйл ажиллагаандаа инновацийг идэвхтэй эрэлхийлж байдаг их сургууль

J. Ropke 1998	Энтрепренер их сургууль нь 3-н агуулгыг илэрхийлнэ. Үүнд: 1/ их сургууль өөрөө энтрепренер байх, 2/ Их сургуулийн гишүүд энтрепренер байх, 3/ их сургууль гадаад орчинтой харилцахдаа нь энтрепренер замыг дагах
(H. Etzkowitz, 2000)	Энтрепренер их сургууль гэдэгт бүс нутаг болон үндэсний эдийн засгийн гүйцэтгэлийг сайжруулах зорилготойгоор энтрепренершип үйл ажиллагааг явуулдаг, мөн их сургуулийнхаа санхүүгийн давуу талыг бий болгож байгаа бүх их сургуулиуд хамаарна.
D.A Kirby 2002	... шинэчлэл өөрчлөлт хийх, боломжийг таньж мэдэх, бүтээх, багаар ажиллах, эрсдлийг үүрэх, аливаа сорилтод харну өгөх чадвартай байдаг
(Etzkowitz, 2003)	... бол академик үндсэн зорилго болон их сургуулийн дээр бий болсон мэдлэгийг нийгэм, эдийн засгийн хувьд ашигтай байлгах зорилгуудыг <u>нэгтгэсэн стратегийн чиглэлийг</u> тодорхойлж, хэрэгжүүлэх чадвартай байдаг.
(M.Meyer, 2003)	... мэдлэг болон технологийг бүтээх, ашиглах, түүнийг өдөөх зорилго бүхий засгийн газар, аж үйлдвэртэй хамтран ажилладаг институцийн шинэ хэлбэр, стратегийг хэрэгжүүлдэг байгууллага.
(M. Jacob, 2003)	... бол мэдлэгийн арилжаалалт (захиалгат сургалт, зөвлөх үйлчилгээ, бусад үйл ажиллагаа) болон бараажуулалт (патент, лиценз, оюутны үүсгэн байгуулсан старт-ап) хоёуланд төвлөрдөг онцлогтой
(Kirby, 2005)	Энтрепренер их сургуулийг бүхий л үйл ажиллагаагаа (санхүүжилтийн олон эх үүсвэртэй байх, сайн багш, оюутныг сонгож авах, чанартай сургалт, судалгаа хийх зэрэг) <u>хамгийн сайн байлгахад чиглэсэн стратегийн</u> хэрэгжилтээрээ өрсөлдөөнт орчинд амьд үлдэгч гэж тодорхойлж болно. Мөн боловсрол болон судалгааны хоорондын холбоог хангахын тулд илүү бүтээлч, бүтээмжтэй байдаг их сургуулиудыг хэлнэ.
(Hannon, 2007)	... гэж санааг арилжаалах боломжийг хамгийн их байлгах аас айддаггүй, академик үнэт зүйлд аюул учирна гэж харалгүйгээр нийгэмд үнэ цэнийг бүтээж байдаг их сургуулийг хэлнэ.
(A. Salamzadeh, 2011)	... бол онцгой орц, процесс, гарцыг багтаасан, гуравдагч зорилгоо биелүүлэхийн тулд нөөц, чадвар, чадавхиа шилжүүлэхийг зорьж буй динамик систем юм.
(Urbano, 2012)	Энтрепренер их сургуулийн үүрэг бол зөвхөн мэдлэг үйлдвэрлэх бүс шинэ мэдлэгийг үйлдвэрлэлд, нийгэмд түгээх байдаг.
(M.Guerrero, 2013)	... бол бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чухал хурдасгуур. Яагаад гэвэл тэд шинэ санаа, технологийг бий болгох, шинэ бизнес эрхлэх, тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх төрөл бүрийн нөөц, чадавхитай төрөлхийн инкубатор юм.
(C. Sam and P. V. D. Sijde, 2014)	... бол нийгмийн хөгжил, инновацийн системд тодорхой үүргүүдийг гүйцэтгэх чадвартай их сургууль. Оролцогч талуудтай харилцан үйлчлэл, ойр хамтын ажиллагаагаараа шинэ мэдлэг, технологийг үйлдвэрлэх, хөгжүүлэх мөн мэдлэгт суурилсан нийгэмд байр сууриа хүчирхэгжүүлэх, орлогын шинэ эх үүсвэрийг бий болгох чадвартай гэж хүлээн зөвшөөрөгддөг байгууллага.

(Audretsch, 2014)	... гишүүдийн энтрепренер сэтгэлгээ, үйл ажиллагаа, институциудын хамтын хөгжил, энтрепренершиг хөрөнгө оруулалт зэрэгт хувь нэмэр оруулж, манлайлал үзүүлж чаддаг.
(M. Guerrero, 2015)	Энтрепренер их сургууль өөрчлөлтөд дасан зохицох чадвар, менежмент болон засаглалын өвөрмөц байдал, энтрепренер соёлыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, судалгааг арилжаалах, шинэ бизнесийн бий болгох замаар эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр оруулах... зэргээр бусдаас ялгарах онцлог шинжүүдтэй байдаг.
Ч. Ганзориг МУИС, доктор, профессор	Академик мэдлэгийн бизнесийн сэтгэлгээтэй холбож, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, санхүүгийн хувьд бие даасан сургуулийн бүтцийг “энтрепренер” их сургууль гэнэ.

Энтрепренер их сургууль байхын учир шалтгаан

Олон улсад их сургуулиудын эдийн засгийн хөгжилд оруулах боломжит хувь нэмрийн талаар урт хугацааны туршид хэлэлцсээр ирсэн. Түүхчид Британы аж үйлдвэрүүд эдийн засгийн гурав болон дөрөвдүгээр кондратифийн үед хими болон цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлээр хоцрогдож байсны гол шалтгаан нь тухайн үеийн Британы их сургуулиуд байгалийн шинжлэх ухаан, инженерийн салбарт багшлах болон судалгаа хийх чадвараар Америк болон Германы техникийн их сургуулиудаас сул байсантай холбоотой гэж тайлбарладаг. Учир нь техникийн их сургууль болон компаниудын ойр хамтын ажиллагаа нь Германыг аж үйлдвэрлэгч орнуудыг тэргүүлэхэд хүргэсэн (Chandler, 1967). Харин Америкийн фирмүүд тав, зургаадугаар кондратифын үед инновацийн үйл ажиллагаагаараа дэлхийд тэргүүлж байсан нь энэ үеийн Америкийн сургалт, судалгааны институциудын энтрепренершигийг хөгжүүлэхэд гаргасан хүчин чармайлттай холбоотой. АНУ-аас эхтэй аж үйлдвэрлэлд түшиглэсэн их сургуулийн хөгжлийн хандлага дэлхийн улс орнуудын анхаарлыг татаж, олон улс оронд түгэн дэлгэрч, их сургуулиуд өөрсдөө инновацийн агент, энтрепренер болж сургалт, судалгааны үр дүн, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, бүс нутаг, улс орны хөгжилд хувь нэмэр оруулах гуравдагч зорилгыг төлөө ажилладаг болсон нь чухал ач холбогдолтой байна.

Судлаачид их сургуулийн уламжлалт загвараас энтрепренер их сургуулийн загварт шилжих үндсэн шалтгаануудыг дурьдсан байдаг. Үүнд:

Их сургууль дээр хийгдэж буй шинэ нээлт, судалгааны үр дүн нь шинжлэх ухааны нэр хүндийг өсгөж байгаа хэдий ч аж үйлдвэрлэл болон эдийн засгийн салбарт оруулах хувь нэмэр бага байна (Rцрке, 1988),

Их сургууль зөвхөн хөдөлмөрийн зах зээлд мэргэжилтэн нийлүүлэх бус улс орон, бүс нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах нөөц, чадавхи

бий (Maribel Guerrero, 2010), (Leydesdorff, 2001)

Их сургууль олон улсад өрсөлдөх чадвартай байхын тулд хөгжлийн чиг хандлагаа өөрчлөх зайлшгүй шаардлага байна (Рорке, 1988), (Leydesdorff, 2001) г.м

Тэгэхээр энтрепренер их сургууль гэдэг бол шинжлэх ухааны чадавхи, судалгааны суурь, нөөц дээрээ үндэслэн шинэ технологи, инновацийг бий болгох, нэвтрүүлэх, патент эзэмшиж ашиглуулах, өндөр технологийн компаниудыг төрүүлэн гаргах замаар өрсөлдөх нэмэгдүүлж, улмаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг их сургуулийн шинэ загвар юм.

Энтрепренер их сургуулийн үүрэг, ач холбогдол

Шинэ мэдлэгийг боломж болгон хөгжүүлэх, мэдлэгийн хэрэглээг нэг байгууллагаас нөгөө байгууллага руу шилжүүлэх гэдэг нь тийм ч амар зүйл биш. Их сургуулийн профессор, эрдэмтэд өөрсдийн мэдлэг, туршлага дээр суурилан олон төрлийн судалгаа, судалгааны бүтээл гаргадаг боловч тэдний ихэнх нь бүтээмжийг дээшлүүлэх, баялагийг нэмэгдүүлэх боломж болж чаддаггүй. Харин энтрепренерүүд боломжийг олж харж, шинэ санааг зах зээлийн хэрэглээнд нийцүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хувиргаж чаддаг. Тиймээс их сургуульд хийгдэж байгаа судалгааны үр дүнг өндөр байлгах, тэдгээрийг хэрэглээнд оруулах энтрепренершиппийг улам бүр хөгжүүлэх хэрэгтэй Рорке (1998). Энтрепренершип бол өрсөлдөх чадвар, өсөлт хөгжлийн гол түлхүүр болохыг хүлээн зөвшөөрч их сургуулиуд дараах чиг үүргүүдийг хүлээх болжээ. Үүнд:

- ✓ Байгууллагын бүх гишүүдийн энтрепренер сэдэл, зан төлөв, соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн алсын хараа, бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- ✓ Нийгэмд ажлын байр бий болгох, шинэ бизнес эрхлэх мэдлэг, чадвартай энтрепренерүүдийг төрүүлэн гаргах, энтрепренершип боловсрол олгох
- ✓ Мэдлэгийг капиталжуулах, арилжаалах, технологийн инновацийг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх
- ✓ Нийгэмд энтрепренершиппийн хөгжүүлэхэд манлайлах, оролцогч талуудтай хамтран ажиллахдаа энтрепренер замналыг мөрдөх
- ✓ Бүс нутаг, улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах

Дээр дурьдсанчлан их сургууль энтрепренер чиг баримжаатай хөгжлийн загварыг дагаснаар засаглалын хувьд бие даасан байх, санхүүжилтийн олон

эх үүсвэртэй болох, үйл ажиллагааны хил хязгаараа тэлж илүү өргөн хүрээнд хөгжиж дэвших, олон улсад өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, мэдлэгийн эдийн засагт оруулах хувь нэмрээ өсгөх гэх мэт олон талын ач холбогдолтой байна.

Дүгнэлт

19-р зуунаас эхтэй “бүс нутгийн аж үйлдвэрийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах эрдэм шинжилгээ судалгааны ажилд түшиглэсэн их сургууль”-ийн /МГТ/ загвар нэгэн зууны туршид илүү өргөжин хөгжиж энтрепренер их сургууль хэмээх хөгжлийн шинэ хэв маяг бий болсон байдаг. Өдгөө дэлхий даяар олон мянган их сургуулиуд энэхүү үзэл баримтлалаар хөгжих стратегийн шинэчлэл, шилжилт хийж, тулгарч буй шинэ сорилтыг даван туулахад асар их хүчин чармайлт гаргасаар байна. Манай улсын хувьд төрийн өмчит томоохон сургуулиуд судалгааны их сургууль болох зорилгыг өмнөө тавин ажиллаж байгаа хэдий ч мэдлэгт суурилсан нийгмийн хөгжилд зохицон өөрчлөгдөх явц удаашралтай байгаа нь бид хөгжлийн стратегиа эргэн харах, өөрчлөх зайлшгүй шаардлага байна гэдгийг судлаачдийн зүгээс дүгнэж байна.

Бид энэхүү судалгааны ажлаараа мэдлэгийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, арилжаалах их сургуулийн загвар түүний түүхэн хөгжил, мөн чанар, ач холбогдлыг харуулахыг зорьсон нь цаашдын судалгааны ажлын орон зай, хэрэгцээг олж харах, энэ чиглэлээр судалгааны ажлуудыг монгол улсын их сургуулиудын жишээн дээр гүнзгийрүүлэн судлах, үр дүнг таниулан сурталчилах, хэлэлцүүлэх, цаашид бодлогын түвшний судалгаа хийх урьдач нөхцөл болно гэж үзэж байна. Манай улсын хувьд академик энтрепренершип, энтрепренер их сургуулийн хөгжил, стратеги, түүнийг хэрэгжүүлэх боломжийн талаарх судалгааны ажлууд тун ховор байна. Цаашид хувь хүн /багш, оюутан/, байгууллагын түвшин болон институциудын түвшинд энтрепренершипийг хөгжүүлэх судалгааны ажлуудыг хийх хэрэгцээ, шаардлага байна. Үүнд:

1. Хувь хүн /багш, оюутан/-ийн хүрээнд: энтрепренер болох сэдэл, хүсэл эрмэлзэл, хандлага, оролцоо, итгэл үнэмшил, ур чадварууд мөн тэдгээрт нөлөөлөх, дэмжих хүчин зүйлсүүд;
2. Их сургуулийн хүрээнд: академик энтрепренершипийг хөгжүүлэхтэй холбоотой байгууллагын доторх бүтэц, зохион байгуулалт, стратеги, манлайлал, соёл, дэд бүтэц, гадаад харилцаа холбоо, орчны хүчин зүйлс, институци хоорондын хамаарал;
3. Энтрепренершипийг дэмжих орчны хүрээнд: энтрепренер экосистемийн хөгжил, нөлөөлж буй хүчин зүйлс, экосистемийн гол тоглогчдын үүрэг, хоорондын уялдаа холбоо, хамаарал, венчур хөрөнгө оруулалт,

санхүүжилтийн эх үүсвэрүүд, төрийн бодлого, зохицуулалтууд түүний үр өгөөж, цаашлаад нийгэм эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр зэрэг асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, судалгааны үр дүнг олон нийтэд таниулах, сэдвүүдийн хүрээнд илүү нарийн, үр өгөөж бүхий судалгаа, шинжилгээ боломж, орон зай маш их байна.

Ашигласан материал

- A. Salamzadeh, Y. S. (2011). "Toward a systematic framework for an entrepreneurial university: A study in Iranian context with an IPOO model". *Global Business and Management Review: An International Journal*, vol. 3, no. 1, pp. 30-37.
- Audretsch, D. B. (2014). From the entrepreneurial university to the university for the entrepreneurial society. *The Journal of Technology Transfer*, vol. 39, no. 3, pp. 313-321.
- C. Sam and P. V. D. Sijde. (2014). Understanding the concept of the entrepreneurial university from the perspective of higher education models. *Higher Education*, vol. 68, no. 6, pp. 891-908.
- Chandler, A. D. (1967). *Strategy and Structure*. Cambridge, Mass: MIT press.
- Clark, B. R. (1998). *Creating Entrepreneurial Universities: Organizational Pathways of Transformation*, Oxford. Pergamon for IEU Press.
- Cole, A. H. (1949). Entrepreneurship and entrepreneurial history. *Change and the Entrepreneur*, 88-107.
- Davies, J. L. (1987). "The entrepreneurial university". *International Journal of Higher Education Management*, vol. 11, no. 1, p. 227.
- Dollinger, M. J. (2008). *Entrepreneurship Strategies and Resources*, ISBN 978-0-9713130-6-4. MARSH PUBLICATIONS Lombard, Illinois U.S.A.
- Donald S. Siegel, M. W. (2015). Academic entrepreneurship: time for a rethink? . *ERC Research Paper No.32* , 2-38.
- Erik Stam. (2008). Micro-foundations for Innovation Policy. In *ENTREPRENEURSHIP AND INNOVATION* (pp. 135-171). Amsterdam University Press, URL: <https://www.jstor.org/stable/j.ctt46mwvr>.
- Etzkowitz, H. (2003). Research groups as „quasi-firms□: The invention of the entrepreneurial university. *Research Policy*, vol. 32, no. 1, pp.

109-121.

- Etzkowitz, H. (1998). The norms of entrepreneurial science: cognitive effects of the new university–industry linkages. *Research Policy* 27, 823–833.
- Etzkowitz, H. (2003). Research groups as ‘quasi-firms’: the invention of the entrepreneurial university. *Research Policy* 32, 109-121.
- Etzkowitz, H. (2013). Anatomy of the entrepreneurial university. *Social Science Information* 52(3), 486-511.
- Gartner, W. B. (1988). Who is an entrepreneur? Is it the wrong question. *Entrepreneurship Theory and Practice*, -68.
- H. Etzkowitz, A. W. (2000). The future of the university and the university of the future: Evolution of ivory tower to entrepreneurial paradigm. *Research Policy*, vol. 29, no. 2, pp. 313-330.
- H.Etzkowitz. (June 1983). Entrepreneurial Scientists and Entrepreneurial Universities in American Academic. *Minerva* , June 1983, Vol. 21, No. 2/3, pp. 198-233.
- Hannon, A. G. (2007). Towards the Entrepreneurial University, UK:. *Durham and Birmingham*.
- Jain, S. G. (2009). Academics or entrepreneurs? Investigating role identity modification of university scientists involved in commercialisation activity. *Research Policy* 38, 922–935.
- Joy,T. (2015). *Innovation and Entrepreneurship*. ProQuest Ebook Central, <http://ebookcentral.proquest.com/lib/unive3-ebooks/detail.action?docID=4946361>.
- Kirby, D. A. (2005). Creating entrepreneurial universities in the UK: Applying entrepreneurship theory to practice. *Journal of Technology Transfer*, vol. 31, no. 5, pp. 599-603.
- Leydesdorff, L. E. (2001). The transformation of university–industry–government relations. *Electronic Journal of Sociology* 5 (4).
- Louis, K. B. (1989). Entrepreneurs in academe: an exploration of behaviours among life scientists. *Administrative Science Quarterly* 34, 110–131.
- M.Guerrero, J. A. (2015). Economic impact of entrepreneurial universities “activities: An exploratory study of the United Kingdom. *Research Policy*, vol. 44, no. 3, pp. 748-764.
- M. Jacob, M. L. (2003). “Entrepreneurial transformations in the Swedish University system: The case of Chalmers University of Technology” . *Research Policy*, vol. 32, pp.1555-1568.
- M.Guerrero, D. a. (2013). Entrepreneurial universities: Socioeconomic

- impacts of academic entrepreneurship in a European region. *Economic Development Quarterly*, vol 27, no.1, pp. 40-45.
- M.Kirzner. (1977). Entrepreneurial Discovery and the Competitive Market Process: An Australian approach. *Journal of Economic Literature*, Vol 35, Issue 1, 60-85.
- M.Meyer, L. L. (2003). "Triple helix indicators of knowledge-based innovation systems". *Scientometrics*, vol. 58, no. 2, pp. 191-203.
- Maribel Guerrero, D. U. (2010). "The development of an entrepreneurial university, J43-74. 43-74, 43-74.
- Martin, B. (2012). Are universities and university research under threat? Towards an evolutionary model of university speciation. *Cambridge Journal of Economics*, 36, 543-56.
- Murray B. Low, I. C. (1988). Entrepreneurship: Past Research and Future Challenges. *Journal of Management*, Vol.14. No. 2, 139-161.
- Neck, H. N. (2018). *Entrepreneurship: The Practice and Mindset*. Los Angeles, CA.
- Robert D. Hisrich, P. &. (2008). *Entrepreneurship*. Irwin/McGraw Hill.
- Robert Ronstadt, K. H. (1988). Entrepreneurship: Today Courses, Tomorrow Degrees? *Entrepreneurship Theory and Practice*, Vol 14, Issue 1.
- Roberts, E. (1991). *Entrepreneurs in High Technology. Lessons from MIT and Beyond*. New York and Oxford: Oxford University Press.
- Rippke, J. (1988). *The Entrepreneurial University*.
- Schulte, P. (2004). The entrepreneurial university: a strategy for institutional development. *Higher Education in Europe*, Volume 29, Issue 2, 187-191.
- Shane, S. (2003). *A General Theory of Entrepreneurship: The Individual-Opportunity Nexus*. Edward Elgar, Cheltenham, UK/Northampton, MA, USA.
- Simon C. Parker, M. V. (2010). Group Status and Entrepreneurship. *Journal of Economic and Management Strategy*, Vol19, Issue 4, 910-945.
- Stevenson, H. H. (1990). A Paradigm of Entrepreneurship: Entrepreneurial Management. *Strategic Management Journal*, 17-27.
- Tidd, J. B. (2015). *Innovation and Entrepreneurship, Third edition*. Wiley ISBN: 978-1-118-99309-5.
- Urbano, M. G. (2012). The development of an entrepreneurial university . *The Journal of Technology Transfer*, vol. 37, no. 1, pp. 43-74.